

Хөгжмийн багшийн түүвэрт сонгогдсон хүүхдийн гүйцэтгэх даалгавар-багшид

Даалгаврын дугаар: 1	Бүлэг: Бэлтгэл	
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй	Сургалтын чиглэл: Хөгжим	
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: III	Танин мэдэхүйн түвшин: Задлан шинжлэх	
Илрүүлэх чадвар: Хөгжмийн хэмнэл, хурдан, удаан, чанга, сулыг ялган сонсох, дуу авиа, хөдөлгөөн, үгээр илэрхийлэх	Интеграци эсэх: Үгүй	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай	
Даалгавар	“Хурдан уу? удаан уу?”	
Хэрэглэгдэхүүн	Удаан, хурдан хэмнэлтэй аудио бичлэг https://www.youtube.com/watch?v=0aaKPkN1iIM	
Даалгаврын заавар	Багш эхний удаа хүүхдэд хөгжмийн аяыг сонсгосны дараа ямар өөрчлөлт гарч байгааг хүүхдээс асууна. Хүүхэд аяыг сонсоход аль хэсэгт удаан, хурдан байсан хурдан, удаан хэмнэлийг ямар амьтны хөдөлгөөнөөр дүрсэлж болохыг хэлнэ. Багш хоёр дахь удаа аяыг эхлүүлэхийн өмнө хүүхдэд ая эхэлмэгц хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийхийг сануулна. Хүүхэд аяыг сонсоод удаан, хурдан хэмнэлд тохируулан хөдөлгөөнийг/алхах гүйх, эсвэл амьтдын хөдөлгөөн/ хийнэ.	
Даалгаврыг явуулах аргачлал	<i>Багшийн хэлэх үг</i>	
	Багш нь хөгжим сонгоно. Хөгжмийн аялгууг анхааралтай сонсоорой. Аялгууг сонсоход ямар өөрчлөлт гарч байна вэ? (удаан, хурдан) Удаан, хурдан хэмнэлийг ямар амьтны хөдөлгөөнөөр зүйрлэж болох талаар асууна. (хүүхэд баавгай, туулай, яст мэлхий гэх мэт хурдан, удаан хөдөлгөөнтэй амьтныг нэрлэнэ.) Багш нь аяыг дахин сонгоно. Аяыг эхлэхээс дуусах хүртэл хэмнэлд тохирох хөдөлгөөнийг хийгээрэй. /харуулаарай, илэрхийлээрэй гэх эмт/	<i>Багшийн хийх үйлдэл</i>
Дэмжлэг	Хүүхдэд ажиглах, эргэцүүлэн бодох, зөв нэрлэх, үйлдлийг хийхэд хугацааг өгч хүлээцтэй байна. Багш даалгаврыг хэрхэн гүйцэтгэх талаар биечлэн хийж үзүүлэхгүй.	
Анхаарах зүйл	Шаардлагатай үед өөр аудио бичлэг ашиглаж болох ч удаан, хурдан хэмнэлийг бүрэн илэрхийлсэн байхаар сонгоно. “Удаан, хурдан хэмнэлтэй хэсэгт”-гэдгийг хүүхдэд ойлгомжтой байдлаар хэлнэ./хөгжмийн аялгуу удаан, хурдан дуугарах, сонсогдох үед гэх мэтээр/	

Даалгаврын дугаар: 2		Бүлэг: Бэлтгэл	
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй		Сургалтын чиглэл: Хөгжим	
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин:III		Танин мэдэхүйн түвшин: Ойлгох	
Илрүүлэх чадвар: Дууны өнгө, хэмнэлийг алдалгүй хөгжмийн хамсраатай болон хамсраагүй дуулах /дууны аяыг аялгуугаар нь таньж, хөгжмийг дагаж дуулна/		Интеграци эсэх: Үгүй	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Гүйцэтгэлээр		Даалгаврын хэлбэр: Задгай	
Даалгавар	“Хөгжилдөн дуулцаая”		
Хэрэглэгдэхүүн	Хүүхдэд заасан дууны аялгуу/фонограмм/, эсвэл цахилгаан даралтад хөгжим, төгөлдөр хуур Багшийн өмнө нь заасан дууны ая/гурван бадаг/ Жишээ нь: Ая: Б. Цэвээнсүрэн Үг: Дашдондог “Яргуй дэлгэрлээ” дуу https://www.youtube.com/watch?v=WSN39bl-7o8		
Даалгаврын заавар	Багшийн өмнө нь заасан дууны аялгууг сонсоно, эсвэл багш аялгууг хөгжимдөнө. Дууны аялгууг хөгжимдөх, хоолойгүй фонограмм бичлэгийг эхлүүлэх гэж байгааг хүүхдэд сануулж хэлнэ. Дууны аялгууг сонсоод хөгжмийг дагаж дуулна.		
Даалгаврыг эхлүүлэх аргачлал	<i>Багшийн хэлэх үг</i>		<i>Багшийн хийх үйлдэл</i>
	-Дууны аялгууг сонсоё, анхааралтай сонсоорой. -Дууны аялгууг фонограмм бичлэгийг сонсоно. -Дууны аяыг сонсоод дагаж дуулаарай.		Дууны фонограммыг эхлүүлж өгнө, эсвэл багш хөгжимдөнө. Дууны аялгууны эхний бадаг, дахилтын аялгууг сонсоно./хөгжимдөнө/
Дэмжлэг	- Дууны үгийг мартсан болон дутуу мэдэж байгаа тохиолдолд багш нэг 2 мөрийг нь хэлж өгч сануулна.		
Анхаарах зүйл	- Үнэлгээний баг нь дууны сонголтыг хийхдээ хөгжмийн багшийн тухайн бүлэгт заасан дууны жагсаалтаас сонгоно. - Дууны нэрийг хүүхдэд хэлэхгүй. - Дууны фонограмм бичлэг, эсвэл багш хөгжимдөх бол аялгуу нь тухайн насны хүүхдийн хоолойн цараанд тохирсон байна.		

Даалгаврын дугаар: 3		Бүлэг: Бэлтгэл
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй		Сургалтын чиглэл: Хөгжим
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: III		Танин мэдэхүйн түвшин: Бүтээх
Илрүүлэх чадвар: Дуу авиа, зан байдал, хөгжмийн хэмнэлийг энгийн хөгжмийн зэмсгээр илэрхийлэн тоглох /багшийн удирдлагаар хэмнэлийг хамтлагаар тоглоно/		Интеграци эсэх: Үгүй
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Гүйцэтгэлээр		Даалгаврын хэлбэр: Задгай
Даалгавар	“Хэмнэлээр наадацгаая”	
Хэрэглэгдэхүүн	Савх мод, хэц, кастанет, бөмбөр, хэлхсэн шагай зэрэг өндөрлөггүй хөгжмийн зэмсэг дөрвөн ширхэг Хэмнэлийн дасгал: https://youtu.be/AlxA0Cf_hWA	
Даалгаврын заавар	Багш өгөгдсөн хэмнэлийг сонсоно. Хүүхэд хөгжмийн зэмсгийг сонгож авна. Багш, үнэлгээний баг хамтран хэмнэлийн дасгалын дагуу энгийн хөгжмийн зэмсгийг ашиглан хөгжимдөж хүүхэд бүрд нэг удаа сонгоно. Хэмнэлийн дасгал нь нийт 8 такт байгаа бөгөөд эхний 6 тактад хүүхэд бүр өөрийн сонгосон хөгжмийн зургийг харж тохирох хөгжмийн зургийн дагуу хөгжимдөнө. Харин 7,8 тактад 4 хүүхэд зэрэг хөгжимдөнө. Хүүхэд бүр өөрийн сонгож авсан хөгжмийн зэмсгийг ашиглан багшийн удирдлагаар хэмнэлийг дагаж хөгжимдөнө. Багш хүүхдэд хөгжимдөх ээлж нь/хөгжимдөж эхлэх/ болж байгааг багшийн удирдлагаар /гараар дохих, тухайн хөгжмийн зэмсгийн нэрийг хэлэх гэх мэт/ дохиогоор хэлж сануулна.	
Даалгаврыг эхлүүлэх аргачлал	<i>Багшийн хэлэх үг</i>	<i>Багшийн хийх үйлдэл</i>
	- Багш нь хэмнэлийг сонсоно. Анхааралтай сонсоорой. Сонссон хэмнэлийг нь багш нь хөгжимдөж үзүүлье. Үүний дараа энд байгаа хөгжмийн зэмсгээс нэгийг сонгон авч хэмнэлийн дагуу хөгжимдөөрэй. -Дэлгэцэд хэмнэлийн дасгалыг эхлүүлнэ. Хүүхэд сонгосон хөгжмөөрөө хэмнэлийн дагуу хөгжимдөнө.	-Хэмнэлийн дасгалын дагуу багш, үнэлгээний баг хэмнэлээр 1 удаа хөгжимдөж үзүүлнэ. Даалгаврын явцад шаардлагатай тохиолдолд дахин 1 удаа үзүүлж болно. -Хүүхэд хэмнэлийг зөв, тоглож байгаа эсэхийг ажиглаж тэмдэглэнэ.
Дэмжлэг	- Хүүхэд эргэлзэх болон тогтож сонсохгүй байгаа тохиолдолд даалгаврыг дахин хэлж өгнө. Дасгалыг дахин сонсоно.	
Анхаарах зүйл	- Үйлдлийг хийхэд хүүхдийг яаруулахгүй байна. Савх мод эсвэл харандаагаар ширээн дээр тогшуулж болно. Хөгжмийн зэмсгийг өөр эд зүйлсээр орлуулан ашиглаж болно. Ингэсэн тохиолдолд хэн аль үед хэний дараа хөгжимдөхийг хэлж сануулна. - Шаардлагатай бол өөр хэмнэлийн аялгууг ашиглаж болно. - Дасгалыг 2 хүүхэд гүйцэтгэх бол хэмнэлийн дасгалын сүүлийн хөгжмийн хэмнэлийг тоглуулахгүй.	

Даалгаврын дугаар: 4		Бүлэг: Бэлтгэл
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй		Сургалтын чиглэл: Хөгжим
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: III		Танин мэдэхүйн түвшин: Бүтээх
Илрүүлэх чадвар: Аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн гүйцэтгэх		Интеграци эсэх: Үгүй
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Гүйцэтгэлээр		Даалгаврын хэлбэр: Задгай
Даалгавар	"Хөгжилтэй бүжиг"	
Хэрэглэгдэхүүн	https://www.youtube.com/watch?v=1SRypfA7Vrw	
Даалгаврын заавар	Дууны дүрс бичлэгийг хүүхэд үзүүлнэ. Бичлэгийг дуурайж, хөгжмийн хэмнэлд тохируулан бүжиглэнэ.	
Даалгаврыг эхлүүлэх аргачлал	<i>Багшийн хэлэх үг</i>	<i>Багшийн хийх үйлдэл</i>
	Бүжгийн бичлэгийг анхааралтай үзээрэй. Хөдөлгөөнийг анхааралтай ажиглаад дагаад хийгээрэй. Одоо дахиад бүжиглэе, дагаад хийгээрэй.	-Бүжгийн бичлэгийг хүүхдэд үзүүлнэ. -Бүжгийн хөдөлгөөний дагуулж хийлгэнэ.
Дэмжлэг	Багш эхний удаад бүжгийн хөдөлгөөнийг үгээр зааварчилж бичлэгийг дагуулж хийлгэнэ. Хоёр дахь удаа хийхдээ хүүхдүүдэд аман зааварчилгаа өгөхгүйгээр зөвхөн хөдөлгөөнийг дагуулж хийлгэнэ.	
Анхаарах зүйл	Үнэлгээг өгөхдөө хоёр дахь удаагийн бүжгийн хөдөлгөөнийг ажиглаж гүйцэтгэлийг тохирох тэмдэглэгээг хийнэ.	